



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 0197

Мөрөн сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн ээлжит XIII хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 01/191 тоот албан бичгийг харгалзан Мөрөн сумын хэмжээнд “Мөрөн хотын ахуйн хог хаягдлын тогтвортой менежмент” төсөл хэрэгжиж байгаатай холбогдуулан сумын хэмжээнд дахивар түүхий эд авах цэгүүдийг нэмэгдүүлэх хүрээнд Уст 5 дугаар багийн нутаг дэвсгэрт дахивар түүхий эд цуглуулах, ангилах агуулах барих иргэн, аж ахуй нэгжийг дэмжих, Мөрөн сумын 2023 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу шинээр газар эзэмшиж байгаа 3106654 төлөвлөлтийн нэгж талбарын дугаартай иргэн Баярмагнай овогтой Хаш-Эрдэнэ (РЭ88061734)-ийн хүсэлтийн дагуу Мөрөн сумын 5 дугаар баг “Жаст ойл” ШТСтанцын хажуу талд байршилтай худалдаа, нийтийн үйлчилгээний зориулалттай 367м2 газрыг 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэн Б.Хаш-Эрдэнэтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (М.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

6717010397